



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 27 өдөр

Дугаар А/475

Алтай хот

Аймгийн бүсийн морин уралдаан
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн зуны төвийн бүсийн морин уралдааныг Есөнбулаг сумд 2022 оны 07 дугаар сарын 27, 28-ны өдрүүдэд, хойд бүсийн уралдааныг 08 дугаар сарын 05, 06-ны өдрүүдэд Баян-Уул сумд, урд бүсийн уралдааныг Халиун сумд 08 дугаар сарын 05, 06-ны өдрүүдэд тус тус зохион байгуулсугай.

2. Хурдан морины унаач хүүхдүүдэд стандартын шаардлага хангасан хувцас хэрэгсэл өмсгөх, түүнчлэн эцэг эх асран хамгаалагч харгалзан дэмжигчээс зөвшөөрөл авах, эрүүл мэндийн үзлэг, эрүүл мэндийн даатгалын үйлчилгээнд хамруулах шаардлагатай тусламж үйлчилгээ үзүүлж, олон нийтийн хэв журмыг сахиулж, хяналт тавин тайлагнаж ажиллахыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (Б.Алтайбаатар), Эрүүл мэндийн газар (Г.Лхагважаргал), Цагдаагийн газар (Н.Эрдэнэ-Очир), аймгийн Морин спорт уяачдын холбоо (А.Дэлгэржаргал)-д тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР



C:/My documents/ZAHNR-3A-4 doc

0201091481